



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГУУЛЬ**

**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА
ЗҮЙН СЕМИНАР**

2015

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙН СЕМИНАР

2014-2015 оны хичээлийн жилд Төгсөлтийн дараах сургууль шинээр доктор хамгаалсан болон докторын дараах сургалтад хамрагдсан багш нарын бүрэлдэхүүнтэйгээр МУИС-ийн нийт магистрант, докторант оюутнуудад зориулан эрдэм шинжилгээний арга зүйн семинарыг 2014 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 2015 оны 05 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл зохион байгууллаа.

Энэхүү семинарын зарлалыг www.num.edu.mn МУИС-ийн албан ёсны вэб-д долоо хоног бүрийн даваа гарагт байршуулдаг бөгөөд МУИС-ийн цуврал гарын авлага болох МЭДЭЭ-9-д хэвлүүлэн мэдээллийг түгээж байсан.

Уг эрдэм шинжилгээний арга зүйн семинарт илтгэл тавьсан багш нарт Захирлын 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/414 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД ПРОФЕССОР, БАГШ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ”-ын 10.4-д заасан В цагийн нийт багц цагаас 1 багц цагийг тооцуулсан.

Уг семинарт таван сургуулийн оюутнууд өргөнөөр хамрагдан судалгааны ажил хийх зөвлөгөө зөвлөмж өгч, арга, туршлага судалдаг үр дүнтэй хэлэлцүүлэг болж өндөрлөлөө.


2014-2015 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ИЛТГЭЛ ТАВЬСАН БАГШ НАРЫН ХУВААРЬ

Намрын улирал	Багшийн нэр	Сургууль, тэнхим	Сэдэв
10 сарын 08	Б. Отгонтөгс	ТДС	Магистр, докторын хөтөлбөрт тавигдаж байгаа шаардлагуудыг танилцуулах, асуултанд хариулах
10 сарын 15	Н.Ууганбаатар	ШУС	Шинжлэх ухааны судалгаа
10 сарын 22	Д. Нарантуяа	ШУС /Математик/	Чанарын судалгааны аргууд
10 сарын 29	Б.Азжая	ШУС /Түрэг судлал /	Судалгааны ажлын үнэ цэнэ
11 сарын 05	Ж.Бат-Ирээдүй	ШУС /Монгол судлал/	Судалгааны ажилд эх хэлний хэрэглээ
11 сарын 12	С.Цогзолмаа	ШУС /Математик/	Тоон судалгаа түүний ач холбогдол
11 сарын 19	Ө.Баярсайхан	ШУС /Биологи/	Шинжлэх ухааны өгүүлэлийг хэрхэн

			нийтлүүлэх, боловсруулах тухай
11 сарын 26	Д.Түмэнбаяр	ШУС /Математик/	Туршилтын судалгаа
12 сарын 03	С.Нарантуяа	ШУС /Социологи/	Асуудалыг шинжлэх ухаан хоорондын судлагдахуунаар олж харахуй
12 сарын 10	П.Владимир	ШУС /Европ судлал/	Менталижет ба ертөнцийг үзэхүй
12 сарын 17	М.Даариймаа	ШУС /Их британи америк судлал/	Эрдэм шинжилгээний өгүүлэл бичихэд анхаарах зүйл
Хаврын улирал			
2 сарын 11	У.Айбек	ШУС /Биологи/	Судалгааны ажлыг зөв төлөвлөх нь
2 сарын 25	Ш.Мэндбаяр	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс	Магистрант, докторант оюутнуудын солилцооны хөтөлбөрийн тухай
3 сарын 04	Б. Отгонтөгс	ТДС	Магистр, докторын төгсөлтийн ажилд тавих шаардлагууд
3 сарын 11	Н.Жавхлантөгс	ШУС /Хими/	Туршилт, судалгааны ажилд онолын тооцооллыг хэрэглэх нь
3 сарын 18	Б.Хишигдэлгэр	ШУС /Ази судлал/	Боловсрол судлалын судалгаанд математик статистикийн арга хэрэглэх нь
3 сарын 25	А.Энхболор	ХШУИС /хэрэглээний математик/	Дипломын ажлыг Latex ашиглан бичих нь
4 сарын 01	Т.Долтуяа	ХШУИС /хэрэглээний математик/	Дипломын ажлыг Latex ашиглан илтгэх нь
4 сарын 08	Б.Оюунсанаа	Хүрээлэн буй орчин	Дэлхийн байгалийн түймрийн экологи, менежмент
4 сарын 15	В.Данаасүрэн	БС /Санхүү/	Диссертаци бичих арга зүй
4 сарын 22	Г.Баярмаа	ШУС /Биологи/	Судалгааны ажлын ёс зүй
4 сарын 29	Д.Энх-Отгон	БС /Менежмент/	Судалгааны эх сурвалжыг дурьдах, ишлэл татах нь
5 сарын 06	Б. Отгонтөгс	ТДС	Плагиаризмд өртөхгүй байх арга зам
5 сарын 13	С.Батцэцэг	ОУХС /Нийтийн удирдлага/	Судалгааны онолыг практикт ашиглах нь

СЕМИНАРЫН ҮЙЛ ЯВЦ


ТДС-ийн захирал Б.Отгонтөгс
“Магистр, докторын төгсөлтийн ажилд
тавих шаардлагууд” илтгэл



ШУС-ийн Биологийн тэнхим У.Айбек
“Судалгааны ажлыг зөв төлөвлөх”
ИЛТГЭЛ



ХШУИС-ийн Хэрэглээний математикийн тэнхимийн багш А.Энхболор
“Дипломын ажлыг Latex ашиглан бичих нь” сэдэвт илтгэл



ОЮУТНУУДЫН САНАЛ, СЭТГЭГДЭЛ



Г.Ганчимэг /Бизнесийн сургуулийн магистрант/

Энэхүү эрдэм шинжилгээний арга зүйн семинарт хаврын улирлаас эхлэн сууж, мэдээлэл сонсож байна. 7 хоног бүрийн зарлалыг харж өөрийн сонирхсон чиглэлийн лекцэнд ирдэг. Ялангуяа судалгааны арга, аргачлалтай холбоотой мэдээлэл авахыг хүсэж энэ чиглэлийн семинарыг сонгодог. Энэхүү семинарт сууснаар дараах зүйлийг шинээр ойлгож авлаа.

1. Судалгааны ажлын бүтэц
2. Судалгааны ажлын график төлөвлөгөө гаргаж ажиллах
3. МУИС-д сурахад ямар дүрэм журам баримталдаг
4. Оюуны хулгайд өртөхгүй байх, ишлэл татах арга аргачлал
5. Судлаачийн ёс зүйн хэм хэмжээг баримтлах
6. Latex бичвэрийн програмыг ашиглах зэрэг олон шинэ мэдээлэл ойлгож авсан үр дүнтэй семинар болсон.

Т.Сайнжаргал /ШУС-ийн хүмүүнлэгийн сургуулийн докторант/



2014 оны хаврын улирлаас эхлэн семинарт сууж, мэдээлэл сонсож байна. Ажил, хичээлээ зохицуулан таслахгүй суухыг хичээдэг. Энэхүү арга зүйн семинар их ач холбогдолтой санагддаг. Учир нь гадаадын өндөр хөгжилтэй улс оронд докторын зэрэг хамгаалж ирсэн залуу эрдэмтэд судалгааны арга зүй, аргачлалтай холбоотой мэдээлэл өгдөг. Ялангуяа өөрийн туулж өнгөрүүлсэн туршлага, алдаа оноогоо ярьдаг нь онолын мэдлэг гэхээсээ ирүү практик туршлага олж авахад чухал байдаг. Нэг хүний лекцэнд суухад нэг болон нэлээдгүй олон шинэ санаа, шийдэл, мэдээлэл, туршлага олж түүнийгээ өөрийн судалгааны ажилд хэрэгжүүлдэг. Манай монголын хувьд ялангуяа МУИС-ийн хувьд бичвэрийн нэгдсэн стандарт, ишлэл зүүлт авах, ном зүйн жагсаалт гаргах зэрэг нь цэгцрээгүй ороо бусгаа байна. Харин

дэлхийн улс орнуудын туршлагыг судлах, мэдээлэл авахад илтгэл тавьж буй багш нар гүүр болж өгдгөөрөө ач холбогдолтой санагддаг.

Д.Ёндонжамц /Хууль зүйн сургуулийн докторант/



Энэхүү эрдэм шинжилгээний арга зүйн семинарт 10 сараас эхлэн сууж байна. Шинэ докторант учир судалгааны арга зүй, аргачлалтай холбоотой мэдээлэл их хэрэгтэй байсан. Бидэнд судалгааны арга зүйн чиглэлийн хичээл ордоггүй учир энэхүү семинараар мэдээлэл авч байна. Семинарт сууснаар дараах мэдээллүүдэд дэлгэрэнгүй хариулт авч чадсан.

1. Диссертацийн ажлын бүтэц
2. Судалгааны ажил хэрэгтэй мэдээллийг хэрхэн цуглуулах /Data/
3. ЭШӨ хэрхэн бичих, тавигдах шаардлага, хэвлэх нийтлүүлэх боломж
4. Судалгаа хийхэд анхаарах зүйлс
5. Оюуны хулгайд өртөхгүй байх, зайлсхийх зэрэг олон шинэ зүйл мэдэж авсан.

МУИС-ийн хувьд бичвэрийн нэгдсэн стандарт байхгүй байгаа нь бидэнд хүндрэлтэй байдаг. Учир нь илтгэгч бүр өөр өөрийн сургуульд баримталдаг бичвэрийн стандартыг танилцуулдаг. Бид үүний алийг нь дагах вэ гэдэгт эргэлзээтэй байна. Үүнийг цаашид анхааралдаа аваарай. Магистр, докторын оюутнууддаа хандсан судлагааны арга, аргачлалтай ийм төрлийн үйл ажиллагааг олон зохион байгуулаасай гэж хүсэж байна.